



ДУНДГОВЬ АЙМАГ  
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 28 өдөр

Дугаар 1/109

Амардалай

2023 оны хоёрдугаар ээлжийн цэрэг  
татлагыг зохион байгуулах тухай

Монгол улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4,  
Цэргийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6, дахь заалтыг тус тус  
үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын 2023 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлагын товчоог дараах  
бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Товчооны дарга: С.Нарантунгалаг (ЗДТГ-ын дарга)

Гишүүд: Т.Мөнхтуяа (Эрүүл мэндийн төвийн дарга)

Б.Довуучий(1-р багийн Засаг дарга)

Г.Сосорбурам (2-р багийн Засаг дарга)

Б.Баатарсүрэн (3-р багийн Засаг дарга)

Б.Азжаргал (Хэсгийн төлөөлөгч)

Б.Баярмаа(ЗДТГ-ын нярав)

2.Цэргийн насны залуучуудыг шинжилгээнд бүрэн хамруулах, өмнөх жил  
эрүүл мэндээр тэнцээгүй залуучуудыг эрүүлжүүлэх үзлэгийг зохион байгуулж  
ажиллахыг Эрүүл мэндийн төвийн дарга (Т.Мөнхтуяа)-д үүрэгжүүлсүгэй. .

3.Багийн Засаг дарга нар өөрсдийн багийн цэргийн насны залуучуудад  
цэргийн зарлан дуудах хуудсыг хүргэж удирдан зохион байгуулж оролцуулсугай.

4.Цэрэг татлагын үед нийгмийн хэв журмыг сахиулах, гэмт хэрэг зөрчлөөс  
урьдчилан сэргийлэх, дэг журам сахиулах арга хэмжээг авч ажиллахыг цагдаагийн  
хэсгийн төлөөлөгч (Б.Азжаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГА

М.БАЯРСҮХ

